

# ***НИЙГМИЙН АЖИЛ-НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХАМГААЛАЛ***

## **ЕБС-ИЙН АХЛАХ АНГИЙН СУРАГЧДЫН БЭЛГИЙН БОЛОВСРОЛЫН МЭДЛЭГИЙН ТАЛААРХ СУДАЛГАА**

***Ч. Мядагмаа***  
*Доктор (Ph. D.)*

***Олон улсын Улаанбаатарын их сургууль***  
***Хүүхэд, нийгмийн халамжийн тэнхим***

*chmmaa1012@gmail.com*

***Б. Амарзаяа***  
*Бакалавр оюутан*

***Олон улсын Улаанбаатар их сургууль***  
***Хүүхэд, нийгмийн халамжийн хөтөлбөр***

*zaytszaya244@gmail.com*

***Хураангуй:*** Тус судалгаа нь ахлах ангид суралцаж байгаа өсвөр насны сурагчдын бэлгийн боловсролын мэдлэг хэр хэмжээнд байгаа болон бэлгийн боловсролын талаарх мэдлэгийг хаанаас авдаг болохыг тэдний авсан бэлгийн боловсрол нь бодит амьдрал дээр хэр үр өгөөжтэй байгааг тодруулахад оршино. Судалгааны үр дүнгээс харвал нийт судалгаанд оролцогчдын бэлгийн боловсролын талаарх мэдлэгийн хувьд дийлэнх буюу 86.1% нь бэлгийн боловсролын талаарх мэдлэгтэй гэж хариулсан боловч бэлгийн боловсролын талаар яг юу вэ гэдэг нээлттэй асуултан дээр дийлэнх нь “Тодорхой мэдэхгүй байна” гэж хариулжээ. Бэлгийн талаарх мэдээлэл авдаг эх суваг нь сургууль багш болон интернет гэсэн дэс дарааллаар хариулсан бөгөөд энэ талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцдаггүй байгаа нь гэр бүлийнхэн энэ тал дээр хаалттай гэснийг үзвэл манай улсын хувьд одоо ч энэ сэдэв нээлттэй сэдэв биш байгааг харуулж байна. Түүнчлэн цаашид төр засгийн зүгээс системтэйгээр энэ боловсролыг олгох хэрэгтэй ба гэр бүлийн зүгээс ч энэ тал дээр нээлттэй ярилцдаг байхын чухал гэдгийг онцолжээ.

***Түлхүүр үгс:*** Ахлах ангийн сурагч, бэлгийн боловсрол бэлгийн боловсролын үр өгөөж

### **ҮНДЭСЛЭЛ**

Бэлгийн боловсрол гэдэг нь зэргийн талаар олгогдох цогц хувь хүний насны онцлогт мэдлэг бөгөөд энэ нь өсвөр тохируулан хүний бие махбод ба насныханд бэлгийн талаар зөв түүний үйл ажиллагаа, нөхөн ойлголт болон шинжлэх ухаанч үржихүй, хүний эрх, сэтгэл хөдлөл мэдлэгтэй болсноор өөрийн

бэлгийн үйлийн талаар ойлгоод зогсохгүй бэлгийн харилцааны талаар хариуцлагатайгаар шийдвэр гаргах чадвартай болгох(Shin, Heuwon et al, 2020) боловсрол юм. Түүнчлэн бэлгийн боловсролоор дамжуулан хувийн ариун цэвэр ба бэлгийн харилцаанд хамаарагдах асуудлууд, үүнээс шалтгаалах сэтгэл хөдлөл, үүрэг хариуцлага, нөхөн үржихүйн эрүүл мэнд болон хүний эрх зэргийн талаар зөв зохистой мэдлэг олгох боловсролыг хэлнэ. Энэхүү бэлгийн боловсрол нь хувь хүн өөрийн бэлгийн бойжилттой холбоотойгоор өөрийн бие махбодыг ойлгох, дур хүслийг таньж мэдэх, бэлгийн харилцаанд хариуцлагатай, эерэг хандлагатай болох, бэлгийн дарамт хүчирхийллийн талаар ойлгож мэдэх болон бусад холбогдох эрсдэлийн талаарх мэдлэгийг олгох зорилготой юм. Гэвч хүмүүс ихэнхдээ бэлгийн боловсролыг зөвхөн бэлгийн харилцааны тухай, садар самуун сурталчилсан, зөвхөн охидуудад л хамаатай зүйл, чөлөөтэй ярьж болохгүй, ёс бус сэдэв гэж ташаа ойлгодог байна<sup>10</sup>.

Бэлгийн боловсрол нь бэлгийн бойжилт явагдаж буй өсвөр насныхны хамгийн чухал мэдэх ёстой мэдлэгийн нэг бөгөөд энэ нь тэдний бэлгийн талаарх үнэн зөв ойлголт хийгээд хариуцлагатай харилцаа болон эрүүл мэндийн

байдалд нөлөөтэй. Мэдээлэл авах суваг төрөлжсөн энэ үед сониуч зандаа хөтлөгддөг өсвөр насныхны хувьд бэлгийн харилцаатай холбоотой мэдээллийг баталгаа нотолгоогүй эх сурвалжаас авах нь элбэг. Өсвөр насныхны хувьд насанд хүрэгчдийн хараа хяналтгүй байгаа тохиолдолд интернет нь тэдний сонирхсон бүхий л асуултандаа хариулт авдаг гол хэрэгсэл болсон. Эцэг эхээсээ асууж чаддаггүй зүйлсээ ч интернэтээс хайх бөгөөд бэлгийн өсөлт бойжилт, сэтгэл хөдлөлийн өөрчлөлтийн талаар эцэг эх, үе тэнгийнхэнтэйгээ ч нээлттэй ярилцаж чадахгүй байгаа сэдвээ интернетээс хайснаар(UNICEF, 2019) энэ нь тэдний бэлгийн харилцааны талаарх зохист үнэт зүйлийг бий болгоход тус болдог эсэх нь эргэлзээтэй юм. Залуучуудын хандлага, зан төлөвт хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө их бөгөөд бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдээллийн хамгийн түгээмэл эх сурвалж бол интернет, үе тэнгийнхэн, эцэг эх юм (UNFPA, 2017).

Бэлгийн боловсролын талаарх мэдээллийн дутмаг байдал болон зөв бус мэдээлэл нь хүмүүсийг зөв бурууг үнэлэх үнэлэмжийг бууруулдаг төдийгүй зохисгүй бэлгийн үйлдлийг хийхэд

---

<sup>10</sup> Canada Fund for Local Initiatives(2021) “Сургууль эмнэлэг биш” Канад сангийн дэмжлэгтэйгээр Хөөрхөн

зүрх ТББ, Гүнж төвөөс гаргасан цахим хичээл. <https://youtu.be/1i-g3-nDr8Y>

хүргэдэг (Stanger-Hall & Hall, 2016) бөгөөд тодорхойгүй бүрэн бус мэдээлэл нь бэлгийн харилцааны талаарх гажуудсан ойлголт, бэлгийн зан үйлийн талаарх бүрэн бус ойлголтыг бий болгодог (UNFPA, 2017) тул өсвөр насны хүүхдүүд, тэр дундаа ахлах ангийн сурагчдын бэлгийн боловсролыг хаанаас хэрхэн ямар мэдээлэл авах нь тэдний бэлгийн талаарх үнэн зөв мэдлэг, ойлголтод нөлөөлнө. Системтэй үнэн зөв мэдээлэл бүхий бэлгийн боловсрол нь тэдний бэлгийн эрүүл байдлыг хамгаалж бэлгийн эрүүл мэндийн асуудал үүсэхгүй байхад туслана.

Бэлгийн боловсролгүй эсвэл энэ талаар хагас дутуу мэдлэгтэй байх нь өсвөр насныхны дунд бэлгийн замын халдварт өвчин(БЗХӨ) тархах, эрт жирэмслэх, хүсээгүй жирэмслэлтээс үүдэж үр хөндүүлэх, бэлгийн хүчирхийлэлд өртөх зэргээр бодитоор хэд хэдэн сөрөг нөлөөтэй.

2016 онд БЗХӨ-өөр өвчлөгчдийн 11.9%-ийг 15-19 насныхан эзэлсэн бөгөөд энэ нь Ерөнхий Боловсролын Сургууль (ЕБС)-д 2014 оноос хойш таслалдаад байсан "Эрүүл мэнд"-ийн хичээлийг 2018 онд буцаан оруулахад нөлөөлжээ<sup>11</sup>. Монголын өсвөр үеийнхний цогц хөгжлийн талаарх судалгаанаас үзвэл

сүүлийн үед 14 ба түүнээс дээш насны өсвөр насны охидын дунд бэлгийн замын халдварын тархалт нэмэгдсэн байдлыг өсвөр насныхны бэлгийн бойжилт эрт эхэлж байгаа, мөн охид гэр бүл, дотуур байрандаа бэлгийн хүчирхийлэлд өртдөг, найз залуугийн зүгээс бэлгийн харилцаа тогтоох шахалтад ордогтой холбоотой гэж үзжээ. Түүнчлэн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар ойлголт мэдлэг муутай байдал нь өсвөр насныхныг хүсээгүй нөхцөл байдлаас өөрийгөө хамгаалах чадваргүй болгож, БЗХӨ болон бусад халдвар авах эрсдэлд охид илүүтэй өртөж байна (UNICEF, 2019) гэж дүгнэжээ.

2013 онд хийгдсэн "Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа (НҮТС)"-аас үзвэл Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийг насаар нь үзвэл нийт эмэгтэйчүүдийн 0.1% нь 15 нас хүрээгүй байхдаа, 17.4% нь 15-19 настайдаа анхны хүүхдээ төрүүлжээ(Б.Бүжинтуул, 2018). 2023 онд манай улсад 15-19 насны 124,192 эмэгтэй хүүхэд байгаагаас үүний 1.6% нь буюу 2072 насанд хүрээгүй сурагчид ээж болсон байна (ҮСХ, 2024).

2001 онд Улаанбаатар хотын 8 эмнэлэгт үр хөндүүлэхээр ирсэн 15-49 насны 900 эмэгтэйн 5.7% нь 20 хүртэлх насны өсвөр үеийнхэн

---

<sup>11</sup> Canada Fund for Local Initiatives(2021) "Сургууль эмнэлэг биш" Канад сангийн дэмжлэгтэйгээр Хөөрхөн

зүрх ТББ, Гүнж төвөөс гаргасан цахим хичээл. <https://youtu.be/li-g3-nDr8Y>

байсан(Ж.Дэмбэрэлсүрэн, 2003) бол 2013 онд хийгдсэн НҮТС-аас харвал өсвөр насны охидын үр хөндөлт нь нийт үр хөндөлтийн 6.6% байна (UNICEF, 2019).

2017 онд гарсан “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-н дээр үндэслэн Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос 2020 онд гаргасан үзүүлэлтээр Хамтрагчийн болон бусдын зүгээс хүнд болон дунд хэлбэрийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн нийт 3198 тохиолдол байгаагийн 71 нь 15-19 насны хүүхдүүд байна(ҮСХ, 2020). Үүнээс гадна сүүлийн жилүүдэд хүүхдийн эсрэг онц ноцтой бэлгийн хүчирхийллийн хэргүүд гарсаар байна. Жишээлбэл, 2023 оны 5-р сард Улаанбаатар хотод 8 настай эмэгтэй хүүхдийг хүчиндэж улмаар амь насыг нь хохироосон хэрэг, 2023 оны 11-р сард Дорноговь аймагт 12 настай охиныг хүчиндээд, амийг нь хохироосон хэрэг, 2024 оны 4-р сард Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын 4 цагдаагийн албан хаагч 13 настай охинтой 12 настайгаас нь хойш бэлгийн хавьталд орж, хүчирхийлсэн гэх мэт хэргүүд байна. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлд өртөх нас нь 10-15 нас бөгөөд дийлэнх буюу 40% нь гэр бүл болон хамаатан садны зүгээс үйлдэгдсэн байдаг (М. Чанцалсүрэн & А.Батхишиг, 2022). Хүүхэд, өсвөр насныхан гэр бүлийн

орчиндоо багаасаа эхлэн бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан охидууд бэлгийн боловсролын талаар сайн мэдлэггүйгээсээ болж 14 ба түүнээс дээш насанд хүрч, өөрсдийнхээ эрхийн талаар, эрхийг нь зөрчиж буй үйлдлийн талаар мэдлэгтэй болсон үедээ л энэ талаар мэдээлдэг байна(UNICEF, 2019).

Энэ бүх судалгаа болон мэдээлэлд үндэслэн дүгнэвэл өсвөр насныхны БЗХӨ тусах, эрт жирэмслэх, хүсээгүй жирэмслэлтээс үүдэж үр хөндүүлэх, хүсээгүй бэлгийн харилцаа, бэлгийн хүчирхийлэлд өртөх, цаашлаад хүний эрхийг зөрчсөн маш олон тооны гэмт хэргүүд нь бэлгийн боловсрол муу байгаагийн үр дагавар гэж үзэж болох юм.

## СУДЛАГДСАН БАЙДАЛ

Бэлгийн боловсролыг олгоход бэлгийн талаарх мэдлэг, бэлгийн хандлага, бэлгийн зан үйл, бэлгийн чөлөөт сонголт, гэрлэлт болон бэлгийн талаарх агуулга орох бөгөөд бэлэг (sexuality) нь зөвхөн биологийн талыг бус бэлгийн эрүүл мэнд, сэтгэл зүйн талыг хамааруулсан (Shin, Heywon et al, 2020) өргөн ойлголт юм.

Манай улсын ЕБС-ийн сургалтын хүрээнд бэлгийн боловсролыг дунд ангиас буюу 6-р ангиас эхлэн ‘Эрүүл мэнд’<sup>12</sup> хичээлээр дараах агуулгаар олгож

---

<sup>12</sup> БСШУЯ 6-12-р ангийн ‘Эрүүл мэнд’ хичээлийн сурах бичиг

байна. Үүнд: 6-р ангид (11нас): Эрүүл ба эрүүл бус харилцаа холбоо; Ялгаварлан гадуурхалт ба хүний эрх; Жендэрийн хэвшмэл ойлголт, үр дагавар; 7-р ангид (12 нас): Хүний бэлгийн амьдрал; Үр тогтолт ба жирэмслэлт; Дотно харилцаа ба түүний үр дагавар; 8-р ангид(13нас): Бэлгийн харилцаанд эрт орсноор гарах сөрөг үр дагавар; Бэлгийн чиг баримжаа; Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлага; 9-р ангид (14 нас): БЗХӨ, сэргийлэх арга зам; ХДХВ/ДОХ ба ялгаварлан гадуурхалт; Бэлгийн амьдралтай холбоотой үнэт зүйл, хандлага; Нийгмийн сүлжээ, аюулгүй ашиглах арга зам; 10-р ангид(15 нас): Бэлгийн амьдрал ба хэвлэл мэдээлэл; Бэлгийн зан үйл ба хувь хүний сонголт; Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл, сонголт; Бэлгэвчийн зөв хэрэглээ; Дотно харилцаан дахь эрх, үүрэг, хариуцлага; 11-р ангид (16 нас): Аюулгүй бэлгийн харилцаа, хил хязгаар; Жирэмслэлтийн явц, төрөлт; Хүсээгүй болон эрт жирэмслэлт; Үр хөндөлт, үргүйдэл; Хүний эрхийн зөрчил, Хүчирхийлэлтэй тэмцэх арга зам; 12-р ангид (17 нас): Гэрлэлт ба ирээдүйн амьдралын төлөвлөгөө; Эцэг эх байхын хариуцлага; Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн бэлгийн хариу үйлдэл;

Бэлгийн харилцаан дахь хосын үүрэг, хариуцлага гэсэн агуулгаар олгогдож байна.

Тэгвэл бэлгийн боловсролыг дэлхийн бусад улс орнуудад хэдэн наснаас хэрхэн олгодог талаар авч үзвэл Швед улсын хувьд 1890 оноос эхлэн дэлхий дээр хамгийн анх удаа бэлгийн боловсролыг олгож эхэлсэн улс бөгөөд бэлгийн боловсролыг 4 настайгаас нь эхэлж хүүхдийн нас болон сэтгэхүйн онцлогт тохируулсан хэлбэрээр олгодог байна<sup>13</sup>. Нидерланд улсад мөн 4 наснаас эхлэн анхан шатны мэдлэг өгдөг. Үүнд бусдын хил заагийг хүндлэхээс эхлээд бусдын биенд гар хүрэхээсээ өмнө зөвшөөрөл авах ёстой гэдгээс эхэлдэг. 7 настайд нь хүндлэл болон өөртөө татах байдлыг, 8-9 насанд нь бэлгийн дур сонирхлын талаар, 10-11 настайд нь өсвөр насанд болох өөрчлөлт хайрлах, дурлах, үерхэх, болзох, эрэгтэй эмэгтэй хүний үүрэг зэргийг заадаг<sup>14</sup>. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хувьд Засгийн Газраас нь сургуулийн орчинд 6-8 наснаас эхлэн бэлгийн боловсролыг хичээлийн хүрээнд олгохоор тогтоосон байна. 1969 онд бэлгийн боловсролын талаарх анхны сурах бичгийг хэвлэн гаргаж байжээ<sup>15</sup>. Өмнөд Солонгос Улсад 2015 оноос эхлэн бэлгийн боловсролыг бага

13

[https://www.ohmynews.com/NWS\\_Web/View/at\\_pg.aspx?CNTN\\_CD=A0002817532](https://www.ohmynews.com/NWS_Web/View/at_pg.aspx?CNTN_CD=A0002817532)

14 Mia.H&Kaarina.S,2019.  
<https://www.seisen.com/student->

[life/seisen-post/features/~board/seisen-post/post/the-benefits-of-progressive-sex-education-a-look-into-the-dutch-curriculum](https://www.seisen.com/student-life/seisen-post/features/~board/seisen-post/post/the-benefits-of-progressive-sex-education-a-look-into-the-dutch-curriculum)

15 Euro.who.int <https://bit.ly/3cPna7x>

дунд ангиас олгох болсон бөгөөд тухайн насанд нь тохирсон агуулгаар тодорхой шат дараалал бүхий байдлаар олгодог<sup>16</sup> бөгөөд ахлах сургуульд жилд 10 цагийн хичээлийг заавал үзэх хичээл болгон оруулсан байна (Shin, Hyeon et al, 2020). Австрали Улсад Эрүүл мэндийн боловсролын хүрээнд 7 настайгаас нь бэлгийн боловсролын талаарх хичээл үзэж эхэлдэг. Австрали улс нь хөгжингүй орнуудын дунд бэлгийн замын халдварт өвчний тархалтаараа дэлхийд эхний 3 байранд багтдагтай холбоотойгоор засгийн газраас бэлгийн боловсролыг аль болох эрт авч, түүнээс ичих санаа зовох бус харин амьдралын салшгүй нэг хэсэг гэдгийг ойлгуулахад чиглэдэг байна.<sup>17</sup>

Энэ мэтчилэн дэлхийн олон оронд бэлгийн боловсролыг бага наснаас нь олгодог боловч зарим улс орнуудад хожуу эхлүүлдэг эсвэл бэлгийн боловсролыг чухалчилж үздэггүйгээс эсрэгээрээ сөрөг үр дагавар гардаг байна. Жишээлбэл, Өмнөд Африкт аль хэдийн өсвөр насандаа очсон үед нь бэлгийн боловсролын хичээлийг зааж эхэлдэг. Энэ байдалд нь

16

[https://www.ohmynews.com/NWS\\_Web/View/at\\_pg.aspx?CNTN\\_CD=A0002817532](https://www.ohmynews.com/NWS_Web/View/at_pg.aspx?CNTN_CD=A0002817532)  
17 Victoria State Government  
[https://www.education.vic.gov.au/school/teachers/teachingresources/discipline/physical/Pages/about.aspx?fbclid=IwAR1tStg19jwEkDAD4WOBvZ0z-2ou6RHV2w-qDZ62ND\\_Ufgdopl8v\\_ipE\\_T4](https://www.education.vic.gov.au/school/teachers/teachingresources/discipline/physical/Pages/about.aspx?fbclid=IwAR1tStg19jwEkDAD4WOBvZ0z-2ou6RHV2w-qDZ62ND_Ufgdopl8v_ipE_T4)

UNESCO-аас дүгнэлт хийж хүүхдэд 5 настайгаас нь эхэлж бэлгийн боловсрол олгохыг зөвлөсөн байдаг. Бэлгийн боловсролыг зохих насанд нь бүрэн хүргээгүйгээс болж жилд Өмнөд Африкийн 400,000 гаруй өсвөр насны охид хүсээгүй жирэмслэлтэнд өртдөг.<sup>18</sup> Америкийн нэгдсэн улсын 51 мужийн 37 нь бэлгийн боловсролыг шаардлагагүй гэж үздэг ба ихэнх мужийн сургуулиудыг бэлгийн боловсролын талаар хичээл, сургалт явуулахыг хуулиараа дэмждэггүй. Энэ нь өсвөр насныхныг уруу татсан, өдөөн хатгасан үйлдэл гэж үзсэнтэй холбоотой. Гэвч АНУ-ын энэхүү бодлого нь өсвөр насныхны жирэмслэлт, бэлгийн замын халдварт өвчнийг илүү ихэсгэж байгаа бөгөөд АНУ нь хүсээгүй жирэмслэлт болон бэлгийн замын халдварт өвчний тархалтаараа дэлхийд дээгүүрт ордог ажээ<sup>19</sup>.

## ОНОЛЫН ТАЙЛБАРЛАЛ

Австрийн неврологич бөгөөд сэтгэл судлалын психоанализын үүсгэгчдийн нэг Зигмунд Фройд<sup>20</sup> “Бэлгийн хүслийн тухайд” номдоо тэрээр хүүхдийн бэлгийн хүсэл нь хүний ухамсарт ба ухамсаргүй

18 Tom Jallo(2020) Myths about sex education debunked.  
<https://africanarguments.org/2020/09/sex-ven-myths-about-sex-education-debunked/>

19 Planned Parenthood.  
<https://www.plannedparenthoodaction.org/issues/sex-education/sex-education-laws-and-state-attacks>

20 Зигмунд Фройд(2019) Психоанализ, орч. Л.Энхтүшиг *Psychology Publishing*.

оюун санааны хөгжлийн үндсэн онолын салшгүй нэг хэсэг хэмээн үзэх ёстой хэмээжээ. Хүн төрөхөөсөө л “олон хэлбэрийн бэлгийн өдөөгчтэй” буюу олон төрлийн объектоор таашаалаа хангах боломжтой байна гэж үзэв. Энэ төрөлх зөн, хөшүүргийг тооцож харвал, нярай хүүхэд төрсөн цагаасаа л биеийн хүсэл/бэлгийн таашаалд захирагдан аливаа үйлдлийг хийдэг хэмээжээ. Энэ нь хүн төрөхөөсөө эхлээд бэлгийн таашаалтай байдаг нь хорвоогийн нэг төрлийн хууль гэж хэлж болох юм.

Бэлгийн бойжилт 9-15 наснаас эхэлж хооронд охид, хөвгүүдийн бие махбод болон сэтгэл зүйд олон өөрчлөлт гардаг. Бие махбодын гэдэг охид энэ үедээ нь жирэмслэх буюу хүүхэдтэй болох боломжтой болж байна гэсэн үг юм. Сэтгэл зүйн өөрчлөлт гэдэг нь хүнд дотносож татагдах зэрэг сэтгэл хөдлөл, харилцаанд гарах өөрчлөлт юм (Бусакорн Суриясарн болон бусад, 2020) Бэлгийн бойжилтын үед нөхөн үржихүйн дааврууд ялгарч эхэлснээр хүүхдийн бие нь насанд хүрсэн хүний бие болох өөрчлөлт явагдаж эхэлдэг боловч өсвөр насныхан бие махбодь, оюун санаандаа гарч буй өөрчлөлтийг ойлгохгүй байгаагаас болж эмзэг, арга мухардсан байдалд ордог (UNICEF, 2019).

Хүүхэд, өсвөр насныханд бэлгийн бойжилттой холбоотойгоор биед тодорхой өөрчлөлтүүд гарсаар байхад холбогдох боловсрол болох

бэлгийн боловсрол нь бэлгийн бойжилт явагдаж эхэлснээс хойш явагдаж байгаа нь сул тал байж болох юм. Нөгөө талаар манай улсын дунд ангиас эхлэн “Эрүүл мэнд” хичээлийн хүрээнд олгогдож буй бэлгийн боловсролын үр өгөөж сайн явагдаж байгаа гэдэг нь эргэлзээтэй. Учир нь манай улсын боловсролын тогтолцоонд эрүүл мэндийн тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтнүүд байдаггүй учир энэ хичээлийг биологийн эсвэл биеийн тамирын багш нар зааж байгаа тул сургалтын чанар болоод үр өгөөж муу байна (UNICEF, 2019).

Тиймээс одоогийн нөхцөлд ахлах ангийн сурагчдад бэлгийн боловсролын талаарх мэдлэг хэр үр дүнтэй байгааг тодруулж, ирээдүйд учирч болох эрсдэлийг багасгахын тулд бэлгийн боловсролын талаарх мэдлэгийг хэрхэн олгох талаар судлах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

## **СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

Энэхүү судалгааны зорилго нь ахлах ангид суралцаж байгаа өсвөр насны сурагчдын бэлгийн боловсролын мэдлэг хэр хэмжээнд байгаа болон бэлгийн боловсролын талаарх мэдлэгийг хаанаас авдаг болохыг тэдний авсан бэлгийн боловсрол нь бодит амьдрал дээр хэр үр өгөөжтэй байгааг тодруулахад оршино.

**Судалгааны хамрах хүрээ ба шалгуур**

Тус судалгааг хийхдээ Баянзүрх дүүрэгт харьяалалтай 15-

19 насны 28,506 иргэнийг суурь үзүүлэлтээ болгон тус дүүргийн харьяалал бүхий ЕБС-д суралцаж буй 263 сурагчаас авсан болно. Судалгаанд оролцогч нь ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн дагуу 6-р ангиасаа Эрүүл мэнд хичээлийн хүрээнд бэлгийн боловсролын талаар судалсан, одоо 10-12-р ангид суралцаж буй сурагч.

#### **Судалгааны хэрэглэгдэхүүн**

Судалгаанд 3 бүлэг 39 асуулт бүхий асуумжаар авсан бөгөөд асуумжаа боловсруулахдаа өсвөр үеийнхэн болон залуусын бэлгийн боловсрол, хандлагын талаарх асуумж<sup>21</sup>-ийг ашигласан.

#### **Судалгааны статистик боловсруулалт**

Судалгааг 2024 оны 4-р сард БЗД-н харьяалал бүхий ЕБС-ийн 10-12-р ангид суралцаж буй 263 сурагчаас судалгааг авснаас 12 нь алдаатай байсан тулд 251 судалгаан дээр дүн шинжилгээ хийсэн бөгөөд статистик үзүүлэлтээ SPSS 29.0 программ ашиглан гүйцэтгэсэн.

#### **Судалгааны үр дүн**

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг үзвэл нийт 251 оролцогчийн 38.3% нь эрэгтэй, 60.6% нь эмэгтэй бөгөөд 16-17 насныхан хамгийн их (71.7%) оролцсон байна. Нийт оролцогчийн 95.6% нь гэр бүлийхэнтэйгээ амьдардаг бөгөөд 69.7% нь 4-6 ам бүлтэй өрх, 40.2% нь байшинд,

31% нь орон сууцанд тус тус амьдардаг байна.

Манай улсын хувьд орлого багатай өрхийн, боловсролын түвшин бага эсвэл боловсролгүй ээжийн өсвөр насны хүүхдүүд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хамгийн бага хүртдэг (UNICEF, 2019) тул тус судалгаанд оролцогчдын эцэг эхийн боловсролын түвшинг асуусан бөгөөд боловсролын хувьд аавуудын 49.8%, ээжүүдийн 50.2 % нь бүрэн дунд боловсролтой байна. Түүнчлэн өрх толгойлсон ганц бие эцэг, эхтэйгээ амьдардаг хүүхэд, өсвөр насныхны хувьд зохих хараа хяналт, заавар чиглүүлэггүй өсөх хандлага түгээмэл бөгөөд эцэг эхийн хараа хяналт, халамж дутмаг охид, залуу бүсгүйчүүд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр (UNICEF, 2019) тул судалгаанд оролцогчдоос эцэг эхтэйгээ хамт амьдардаг эсэхийг асуусан ба судалгаанд хамрагдагсдын 70.5% нь аав ээжтэйгээ хоёулантай хамт амьдардаг ба 12 хүүхэд аавтайгаа амьдардаг бол судалгаанд оролцсон 5 хүүхэд тутмын 1 буюу нийт 51 сурагч эхтэйгээ амьдардаг байна.

Судалгаанд оролцогчийн өрхийн сарын дундаж орлогын хувьд 25.1% нь 3 сая төгрөгөөс дээш, 22.3% нь 1,500,001-2,000,000төг бөгөөд тэд аав ээжийнхээ харилцааг 36.3% нь

<sup>21</sup> “Survey on adolescents and youth knowledge, attitudes and behaviors on Sexual

and Reproductive Health and Gender-Based Violence”(2017)

“сайн”, 29.9% нь “маш сайн” гэж үнэлсэн байна.

Судалгаанд оролцогчдын бэлгийн боловсролын талаарх мэдлэгийн хувьд дийлэнх буюу 86.1% нь бэлгийн боловсролын талаар

мэдлэгтэй гэж хариулсан боловч бэлгийн боловсролын талаар яг юу вэ гэдэг нээлттэй асуултан дээр дийлэнх нь “Тодорхой мэдэхгүй байна”(Зураг. 1) гэж хариулжээ.

Зураг 1. Судалгаанд оролцогчдын бэлгийн боловсролын талаарх ойлголт



Судалгаанд оролцогчдын бэлгийн боловсролын талаарх мэдээллийг хаанаас авдаг болохыг олон сонголтот байдлаар асуухад 24,6% нь багш сургуулиас, 22% нь интернэтээс авдаг байна (Хүснэгт. 1). Энэ нь Монгол, Финланд болон

бусад оронд хийгдсэн өсвөр үеийнхний мэдээлэл авах суваг нь дийлэнх нь интернет байдаг(Hong & Hwang, 2013; Kim, Park, & Jung, 2015; UNFPA, 2017; UNICEF, 2019)-тай ойролцоо гарчээ


Хүснэгт 1. Бэлгийн боловсролын талаарх мэдээлэл авдаг суваг

Та бэлгийн боловсролын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ?	N	Хувь
Эцэг эх, гэр бүлээс	49	10.9
Хамаатны хүмүүсээс	5	1.1
Найз нөхдөөсөө	63	14.0
Найз охин/залуугаасаа	15	3.3
Телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээс	85	18.8
<b>Багш, сургууль, хичээлээс</b>	<b>111</b>	<b>24.6</b>
Бэлгийн боловсрол олгох байгууллагуудаас	15	3.3
<b>Интернэтээс</b>	<b>99</b>	<b>22.0</b>
Бусад	9	2.0
Дүн	451	100%

Бэлгийн боловсролгүйгээс гарах сөрөг үр дагаварын талаарх олон сонголтот асуултанд эмэгтэй эрэгтэй оролцогчийн аль аль нь

“Бэлгийн замын халдварт өвчин тусна” “Төлөвлөгөөгүй байхад жирэмсэн болно” гэсэн байна (График1).

График 1. Бэлгийн боловсролгүйгээс гарах сөрөг үр дагавар



БЗХӨ-өөс сэргийлэх хамгийн сайн аргын хувьд олон сонголтот хариулттайгаар асуусан бөгөөд хамгийн их буюу 39.8% нь бэлгэвчний зөв зохистой хэрэглээг сонгосон байна. Энэ нь бэлгийн эрүүл мэндийг сахих хамгийн чухал арга бол бэлгэвч хэрэглэх<sup>22</sup> гэдэгтэй судалгаанд оролцогчийн 10 хүн тутмын 4 нь санал нийлж байгааг харуулж байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 36.1% нь БЗХӨ-өөс сэргийлэхийн тулд бэлгийн боловсролтой байх хэрэгтэй гэдгийг сонгосон нь бэлгийн боловсролын ач


холбогдлын талаар тодорхой хэмжээнд ойлгож байгааг харуулж байна.

БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх хамгийн сайн аргын талаар хүйсийн хувьд авч үзвэл эмэгтэйчүүдийн хувьд дийлэнх нь бэлгийн боловсролтой байх хэрэгтэй гэсэн(103 оролцогч буюу 38,8%) бол эрэгтэйчүүдийн хувьд дийлэнх нь бэлгэвч хэрэглэх(62 оролцогч буюу 54%)-ийг сонгосон (График.2) нь энэ тал дээр хүйсийн хувьд үзэл бодлын ялгаатай гэдгийг харуулж байна.

<sup>22</sup> Centers for Disease Control and Prevention, 2016.

<https://www.cdc.gov/std/prevention/default.htm>.

График 2. БЗХӨ-өөс сэргийлэх арга, хүйсээр



Бэлгийн боловсролыг хэдэн насандаа авбал хамгийн зохистой талаар асуухад нийт оролцогчдын 48.2% нь 11-14 насандаа авбал зохистой(Хүснэгт 2) гэжээ. Судалгаанд оролцогчдын 52.7% нь бэлгийн боловсролыг нэн түрүүнд эцэг эх, гэр бүлийн зүгээс олгох

хэрэгтэй(Хүснэгт 3) гэж үзсэн байгаа нь бусад улс оронд нь эцэг эх гэр бүлийн зүгээс олгох(UNFPA, 2017)-ын чухлыг дурдсантай адил гарч байна. Түүнчлэн 30.3% нь сургууль, багшийн зүгээс бэлгийн боловсрол олгох хэрэгтэй гэсэн байна.

Хүснэгт 2. Бэлгийн боловсрол олговол тохиромжтой нас

Таны бодлоор хэдэн настайдаа бэлгийн боловсролыг авах хэрэгтэй гэж бодож байна вэ?	N	Хувь
6 хүртэлх насандаа	5	2
7-10 наснаасаа	19	7.6
<b>11-14 наснаасаа</b>	<b>121</b>	<b>48.2</b>
15-18 наснаасаа	73	29.1
19-с дээш насандаа	33	13.1
Дүн	251	100%

Хүснэгт 3. Бэлгийн боловсрол хэн олгох хэрэгтэй вэ ?

Таны бодлоор бэлгийн боловсролыг хэн олгох хэрэгтэй вэ?	N	Хувь
<b>Эцэг эх, гэр бүлийн зүгээс</b>	<b>174</b>	<b>52.7</b>
Сургууль, багшийн зүгээс	101	30.3
Засгийн Газрын бодлогын хүрээнд төрийн байгууллагаас	22	6.7
Холбогдох төрийн бус байгууллагаас	26	7.9
Бусад _____	7	2.1
Дүн	330	100%

Бэлгийн боловсролыг эрт олгоогүйгээс гарах сөрөг үр дагаврын талаар нийт судалгаанд оролцогчдын 66.5% нь “Хүүхдүүд бэлгийн харилцаанд эрт ордог” гэсэн бол 47.4% нь бэлгийн боловсролыг бага сургуулиас нь

эхэлж орохтой санал нийлнэ гэсэн байна. Түүнчлэн судалгаанд оролцогчдын 82.5% нь хүүхэддээ бэлгийн боловсрол олгох нь гэр бүлийн үүрэг хариуцлага үзсэн байна (Хүснэгт. 4).

Хүснэгт 4

Асуулт	Хариулт	N	Хувь
Бэлгийн боловсролыг эрт олгоогүйгээс өсвөр насны хүүхдүүд бэлгийн харилцаанд эрт ороход нөлөөлдөг гэж боддог уу?	<b>Санал нийлнэ</b>	<b>167</b>	<b>66.5</b>
	Санал нийлэхгүй	22	8.8
	Мэдэхгүй байна	62	24.7
Таны бодлоор бэлгийн боловсролыг бага сургуулиас нь эхэлж олгох нь зөв гэж бодож байна уу?	<b>Тийм</b>	<b>119</b>	<b>47.4</b>
	Үгүй	56	22.3
	Мэдэхгүй байна	76	30.3
Та бэлгийн боловсролд шашин шүтлэг тодорхой хэмжээгээр нөлөөлнө гэж боддог уу?	Санал нийлнэ	38	15.1
	<b>Санал нийлэхгүй</b>	<b>122</b>	<b>48.6</b>
	Мэдэхгүй байна	91	36.3
Хүүхэддээ бэлгийн боловсрол олгох нь гэр бүлийн үүрэг хариуцлага гэдэгтэй санал нийлэх үү?	<b>Санал нийлнэ</b>	<b>207</b>	<b>82.5</b>
	Санал нийлэхгүй	14	5.6
	Мэдэхгүй байна	30	12

Бэлгийн боловсролын талаар гэр бүлийн зүгээс мэдээлэл өгдөг эсэх асуултанд нийт судалгаанд оролцогчдын 50.6% нь өгдөггүй гэсэн бөгөөд бэлгийн боловсролын талаар гэр бүлийнхэнтэйгээ ярилцдаггүй

шалтгаан нь дийлэнх буюу 59% нь манай гэр бүл энэ тал нээлттэй биш(Хүснэгт. 5) гэж хариулсан нь Монгол улс энэ тал дээр нээлттэй бус(UNICEF, 2019)-тай адил гарсан байна.

Хүснэгт 5

Асуулт	N	Хувь
<b>Энэ тал дээр манай гэр бүлийнхэн нээлттэй биш.</b>	<b>75</b>	<b>59</b>
Би өөрөө гэрийнхнээсээ асуухаас санаа зовоод байдаг	25	19.7
Найз нөхдөөсөө асуух тул гэрийнхнээсээ асууж ярилцах шаардлага байхгүй	18	14.2
Бусад	9	7.1

Харин найзуудтайгаа буюу 78.1% ярилцдаг бөгөөд энэ нь ярилцдаг эсэх дээр дийлэнх нь энэ талаар гэр бүлийнхэнтэйгээ

ярилцахаас илүү найз нөхдийн хүрээнд л илүү ярилцдаг(Hong & Hwang, 2013; Kim, Park, & Jung, 2015) гэх судалгаатай дүйцэж байна.

Судалгаанд оролцсон 251 оролцогчоос 47 нь буюу 18.7% нь бэлгийн харьцаанд орж үзсэн гэсэн бөгөөд үүнийг 1999 онд хийгдсэн дунд сургуульд суралцаж буй сурагчдын бэлгийн харилцаанд ороход нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан судалгаанд хамрагдагсдын 9% нь бэлгийн харилцаанд орсон(А.Солонго, 2003) гэх дүнтэй харьцуулахад 2 дахин өссөн дүн болохыг харж болно. Энэ нь энэ талаарх мэдээллийг интернет зэрэг олон сувгаас авах болсноос тийнхүү авсан мэдээлэл дээрээ үндэслэн сониуч зандаа хөтлөгдсөнөөр эрт бэлгийн харилцаанд орох болсон нь ийнхүү 20 гаран жилийн хугацаанд 2 дахин өсөх шалтгаан болсон гэж үзэж болно.

Тус судалгаанд бэлгийн харилцаанд орж үзсэн 47 оролцогчдын анх бэлгийн харилцаанд орсон дундаж нас нь 15 нас бөгөөд хамгийн залуу нь 13 насандаа орсон байна. Түүнчлэн бэлгийн харилцаанд орсон оролцогчдын 57.4% болох 27 нь сайн дураараа бэлгийн харилцаанд орсон бөгөөд анхны бэлгийн харилцааг нас хамаарахгүй өөрийн шийдвэрээр хийх ёстой гэж үзсэн байна. Дээрх бэлгийн харилцаанд

орж үзсэн 47 оролцогчоос 41 нь хамгаалалт хэрэглэсэн ба 7 нь сэтгэхүйд нөлөөлөх бодис хэрэглэсэн гэсэн байна. Хамгаалах хэрэгслийн хувьд дийлэнх нь бэлгэвч хэрэглэсэн байна. Түүнчлэн хамгийн сүүлд бэлгийн харилцаанд орохдоо 85.2% нь бэлгэвч хэрэглэсэн бол хамгаалалтынхаа талаарх мэдээллийг нийт бэлгийн харилцаанд орж үзсэн 47 оролцогчийн давтагдсан тоогоор 30.9% нь интернэтээс, 22.2% нь найз нөхдөөсөө авсан байна.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь бэлгийн харилцаанд орсноор том болсон мэдрэмж авдаг гэсэн бөгөөд өөрөө хүсэхгүй байсан ч хамтрагчийнхаа хүсэлтээр бэлгийн харилцаанд ордог гэсэн нь өсвөр насны охид найз залуугийн зүгээс бэлгийн харилцаа тогтоох шахалтад ордог(UNICEF, 2019) гэсэн дүнтэй бас дүйцэж байна.

Эцэст нь бэлгийн боловсролын талаар мэднэ гэж хариулсан оролцогчдын хувьд бэлгийн боловсролыг засгийн газрын бодлогын хүрээнд төрийн байгууллагаас системтэйгээр олгох хэрэгтэй гэдгийг хамгийн олон буюу 112 хүн сонгосон нь (Хүснэгт 6) бэлгийн боловсролыг системтэйгээр олгох нь хэр чухал вэ гэдгийг сайн ойлгож байгааг харуулж байна.

Таны бодлоор бэлгийн боловсролыг хэн олгох хэрэгтэй вэ ?	Та бэлгийн боловсролын талаар мэдэх үү ?	
	Тийм	Үгүй
Эцэг эх, гэр бүлийн зүгээс	4	1
Сургууль, багшийн зүгээс	16	3
<b>ЗГ-ын бодлогын хүрээнд төрийн байгууллагаас</b>	<b>112</b>	<b>9</b>
Холбогдох төрийн бус байгууллагаас	57	16
Бусад	27	6
Нийт /N=251/	216	35

### ДҮГНЭЛТ

Тус судалгаагаар ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын бэлгийн боловсролын талаарх мэдлэг мэдээлэл хэр түвшинд байгааг судалсан бөгөөд судалгаанд оролцогчид нь 6-р ангиасаа эхлэн эрүүл мэнд хичээлийн хүрээнд бэлгийн боловсролын талаар суралцаж ирсэн ба энэ мэдлэг нь бодит амьдралд хэр үр дүнтэй байгааг тодруулахыг зорьсон.

Судалгаанд хамрагдагсдын 86.1% нь бэлгийн боловсролын талаар мэдлэгтэй гэсэн боловч дийлэнх нь яг юу гэж тодорхойлохоо мэдэхгүй, эр эмийн харилцаа, үр удмаа үлдээх, секс гэсэн ойлголттой хүүхдүүд багагүй байна. Үүнээс үзэхэд эдгээр хүүхдүүд нь эрүүл мэнд хичээлийн хүрээнд 6-р ангиасаа хойш үзсэн ахлах ангийн сурагчид гэхэд бэлгийн боловсролын талаар тодорхой тогтсон ойлголтгүй байгаа нь манай улсын боловсролын тогтолцоонд эрүүл мэндийн тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтнүүд байдаггүй, энэ

хичээлийг биологийн эсвэл биеийн тамирын багш нар зааж байгаа тул сургалтын чанар болоод үр өгөөж муу байна(UNICEF, 2019) гэдгийг батлан харууллаа.

Манай улсад бэлгийн боловсролыг 6-р ангиас олгож байгаа нь нэг талаар давуу тал боловч нөгөө талаар хүйсийн ялгаанаас үл хамааран анги тус бүр нэг л сурах бичгийн хүрээнд олгож байгаа нь бэлгийн боловсролын үр өгөөжийг бууруулах шалтгаан болж байна. Тус судалгаанд оролцогчид БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх хамгийн сайн аргын талаар эмэгтэйчүүдийн дийлэнх нь бэлгийн боловсролтой байх хэрэгтэй гэсэн бол эрэгтэйчүүдийн дийлэнх нь бэлгэвч хэрэглэхийг сонгосон байгаа нь бэлгийн боловсролын тал дээр хүйсийн хувьд үзэл бодлын ялгаатай байгааг харж болно. Үүнээс гадна бэлгийн талаарх хандлагын хувьд эрэгтэйчүүд илүү хурдан орох бөгөөд эмэгтэйчүүд энэ тал дээр харьцангуй хуучинсаг байдаг(Shin Heywon et al, 2020), ахлах ангийн

сурагчдын хувьд тэдний сургууль дээрээ сурахыг хүссэн бэлгийн боловсрол нь эрэгтэйчүүдийн хувьд жирэмслэхээс сэргийлэх болон жирэмслэлтийг зогсоох(үр хөндүүлэх), БЗХӨ-ий талаар байсан бол эмэгтэйчүүдийн хувьд гэрлэлт болон гэр бүл байгуулах тухай сурахыг хүссэн сурагчид хамгийн их байсан(Lee et al., 2015) зэрэг нь бэлгийн боловсролын агуулгын тал дээр хүйсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч цаашид бэлгийн талаар боловсрол олгохдоо нас тус бүрт тохирсон сэдвээр эрэгтэй эмэгтэйгээр нь ялгаатай агуулгаар ангилсан байдлаар хичээл орох хэрэгтэй гэдгийг харуулж байна.

Мөн тус судалгаанд оролцогчдын нилээн хувь нь бэлгийн талаарх мэдээллийг найз нөхдөөсөө болон интернэтээс авдаг гэсэн бөгөөд энэ нь баттай бус эх сурвалжаас бэлгийн боловсролын талаар ямар ч шүүлтүүргүй мэдээлэл авч байгаа нь нийгэмд хийгээд энэ насныханд сөрөг үр дагавар авчирч болзошгүйг харуулж байна. Тиймээс бэлгийн холбоотой үнэн зөв мэдээлэл бүхий боловсролыг боловсролын байгууллагаас системтэйгээр олгохоос гадна өсвөр үеийнхний ашигладаг сувгуудаар дамжуулан үнэн зөв мэдээллийн хүртээмжийг хангах шаардлага байна. Түүнчлэн бэлгийн боловсролыг зөвхөн боловсролын байгууллагаас төдийгүй эцэг эхчүүд энэ тал дээр илүү нээлттэй хандаж хүүхэдтэйгээ

ярилцдаг байх хэрэгтэй гэдгийг харуулж байна.

### **НОМ ЗҮЙ**

*Монгол хэл дээр*

1. БСШУЯ, 6-12-р ангийн “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичиг.
2. Бусакорн Сурнясарн болон бусад(2020). Амьдрах ухааны сургалт, Хүүхэд, залуучууд, гэр бүлийн эрх, үүрэг, оролцоо. Модуль 6. Бэлгийн боловсрол, ХНХЯ
3. Б. Бүжинтуул(2018). Монгол эмэгтэйчүүдийн анхны төрөлтийн нас, түүнд нөлөөлөгч хүчин зүйлс, Монголын хүн амын сэтгүүл, 2018/28(488), 7-20.
4. Ж. Дэмбэрэлсүрэн(2003). Үр хөндөлтийн шалтгаан сэргийлэх аргын хэрэглээ. Монголын хүн амын сэтгүүл, 2002/9, 13-24.
5. Зигмунд Фройд(2019) Психоанализ, орч. Л.Энхтүшиг Psychology Publishing.
6. А. Солонго. Дунд сургуульд суралцаж буй өсвөр насны сурагчдын гэрлэлтээс өмнөх бэлгийн харьцаанд нөлөөлж буй хүчин зүйлс. Монголын хүн амын сэтгүүл, 2003/9, 43-50.
7. М. Чанцалсүрэн & А. Батхишиг(2022) Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн тархалтын харьцуулсан судалгаа Нийгмийн ажил, 06/2022(13), 51-55.
8. UNICEF(2019) Монголын өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь. Нөхцөл байдлын дүн шинжилгээ. Девелопмент Патвейз.
9. Canada Fund for Local Initiatives(2021) “Сургууль эмнэлэг биш” Хөөрхөн зүрх ТББ, Гүнж төвөөс гаргасан цахим хичээл. (<https://youtu.be/1i-g3-nDr8Y>)
10. ҮСХ(2020) Хамтрагчийг зүгээс үйлдсэн Бие махбод-бэлгийн хүчирхийлэл ҮСХ(2024) Хүн ам зүйн статистик. Гадаад хэл дээр
11. Centers for Disease Control and Prevention, <https://www.cdc.gov/std/prevention/default.htm>
- Euro.who.int <https://bit.ly/3cPna7x>

12. Hong, C. M., & Hwang, E. H. (2013). Relationships among sexual attitudes, sexual knowledge and social support of middle school students. *The Journal of the Korea Contents Association*, 13(8), 240-249.
13. Kim, N. H., Park, Y. J., & Jung, H. S. (2015). Relationships among sexual knowledge, attitude and sexual behavior that university students perceived. *Journal of Psychology and Behavior*, 7(2), 17-42
14. Lee, H. S., Jung, B. Y., Lee, Y. H., Seong, W. S., Ha, J. W., Lee, G. Y., et al. (2015). A study on the level of sex education, sexual knowledge, sexual attitude and sexual allowance among high school students. *Journal of Education & Culture*, 21(3), 231-252
15. Mia. H & Kaarina. S(2019). *The Benefits of Progressive Sex Education - A Look into the Dutch Curriculum*
16. Planned Parenthood. *Sex Education Laws and State Attacks*
17. Shin, Hyewon et al(2020) *An Integrative Literature Review on Sex Education Programs for Korean College Students*, *The Journal of Korean Academic Society of Nursing Education*, Vol.26 No.1, 78-96.
18. Stanger-Hall, K. F., & Hall, D. W. (2016). Abstinence-only education and teen pregnancy rates: Why we need comprehensive sex education in the U.S. *PLoS ONE*, 6(10), 1-11.
19. Tom Jalio(2020) *Myths about sex education debunked.*
20. UNFPA(2017). *Survey on adolescents and youth knowledge, attitudes and behaviors on Sexual and Reproductive Health and Gender- Based Violence. UNFPA Kosovo & Government of Finland..*
21. Victoria State Government <https://www.education.vic.gov.au/school/>